

## АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН НОРМ

Танилцуулга

Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг “Дэд бүтцийн сайдын “Жишиг норм батлах тухай” 2004 оны 19 дүгээр тушаалаар батлан улсын хэмжээнд өнөөг хүртэл мөрдөж байна. Уг нормд 2003 оны байдлаар Монгол Улсад 10-аас дээш тоогоор орж ирсэн марк, загварын автомашинуудад шатахуун зарцуулалт, автомашины эдэлгээний нөөц, резин дугуй, зай хураагуур, агрегат зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарыг тогтоож өгсөн.

Энэхүү нормд орсон автомашинууд нь өнөөгийн байдлаар 15 ба түүнээс дээш жилийн насжилттай дийлэнх нь ашиглалтаас хасагдсан автомашинууд байгаа тул өнөөгийн автопаркийн бүтцэд тохирсон манай орны ашиглалтын нөхцөлийг тусгасан нормыг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон.

Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн боловсруулахад дараах зарчмыг баримталсан. Үүнд

- Автопаркийн бүтцийг 2018 оны байдлаар судалж автомашины ашиглалтын нормыг шинэчлэн тогтоох марк загваруудыг тогтоох
- Түүвэр судалгаагаар сонгогдсон марк загварын автомашины техникийн үзүүлэлтүүдийг үндэслэн шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтооход шаардлагатай үйлдвэрлэгчийн болон гадны орны автомашины техникийн үзүүлэлтийг судлах.
- Автомашины ашиглалтын нормын тогтоосон өөрийн орны болон гадны эрдэмтдийн хийсэн судалгааны ажлуудыг үндэслэх.
- Автомашины шатахуун зарцуулалт, шатахуун зарцуулалтыг өсгөх нөхцөлүүд, хувь хэмжээг хянан, шинэчлэн тогтоохын тулд шатахуун зарцуулалтын туршилт, хэмжилтийн ажлуудыг тодорхой хугацаанд хийх.
- Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн боловсруулахад шаардлагатай судалгаа, хэмжилт туршилтын ажлуудыг хийж жишиг нормын төслийг боловсруулах зэрэг болно.

Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормын төслийг дараах бүтэцтэй боловсруулсан. Үүнд:

### **1 дүгээр хавсралт: Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм**

Автопаркийн бүтцэд 2018 оны байдлаар Монгол Улсад 10-аас дээш тоогоор орж ирсэн 2007 оноос хойш үйлдвэрлэгдсэн 480 гаруй марк загварын автомашинуудын судалгааг хийж монгол орны ашиглалтын нөхцөлийг тусгасан автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг аналитик арга болон туршилт, хэмжилтийн аргын тусламжтайгаар шинэчлэн боловсруулсан. Уг хавсралтад багтсан автомашинуудыг орон нутгийн зам болон хөдөлгөөний эрчим ихтэй

Улаанбаатар хотын зам/хөдөлгөөний эрчмийг тооцсон/-д 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг хэмжээг тогтоож өгсөн.

## **2 дугаар хавсралт: Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд:**

“Дэд бүтцийн сайдын “Жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалын 2-7 дугаар хавсралтуудыг нэгтгэн шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлүүд болох хүйтний улирал, авто зам, ажил үйлчилгээ, авто замын онцгой хүнд нөхцөлүүдийн нэмэгдүүлэх болон хорогдуулах хувь хэмжээг судалгаа, туршилт, хэмжилтийн аргыг үндэслэн шинэчлэн тогтоосон.

Уг хавсралтад тусгасан гол өөрчлөлт нь бүх автомашинд тооцдог хүйтний улирлын нэмэгдлийн хугацаа хувь хэмжээг ялгавартайгаар шинэчлэн тогтоосон. Өөрөөр хэлбэл өнөөгийн автопаркийн бүтцэд ашиглагдаж буй инжектор, дизель, хосолмол /инжектор-цахилгаан/ хөдөлгүүр бүхий автомашинуудад хүйтний улирлын шатахуун зарцуулалтын бодит хэмжээг тогтоох судалгаа, туршилтын ажлын үр дүнг үндэслэн шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хувь хэмжээг гадна хэмээс хамааруулан шинэчлэн тогтоосон. Өнөөгийн мөрдөж байгаа хүйтний улирлын хувь хэмжээ нь Улаанбаатар хотод 12 дугаар сард 5,5 хувь нэмэгдүүлж байгаа бол шинэчлэн тогтоосон нормоор 20 хувиар тогтоогдсон нь 100 км гүйлтэд 10 л зарцуулдаг автомашины хувьд 10,55 л байсныг, шинэчлэн тогтоосон нормоор 12,0 л шатахуун зарцуулахаар болж байгаа юм. Одоо мөрдөж байгаа 5,5 хувь нэмэгдлээр тооцоход хүйтний улиралд автомашины шатахуун зарцуулалт хүрдэггүй тул шатахуун зарцуулалтыг хүйтний улиралд шинэчлэн тогтоолгох явдал их байдаг бөгөөд хүйтний улирлын шатахуун зарцуулалтын бодит хэмжээг үндэслэн тогтоолгосон нормоор дулааны улирлын шатахуун зарцуулалтыг 5,5 хувийг хасан тооцоход дулааны улиралд олгох шатахууны хэмжээ бодит зарцуулалтаас хэт өндөр байдаг байсан.

Мөн Улаанбаатар хотын авто замын ачаалал болон автотээврийн хэрэгслийн тоо 2004 оныхоос эрс өөрчлөгдсөн тул хөдөлгөөний эрчмийн нэмэгдэл буюу Улаанбаатар хотын замд ажиллах автомашинуудын шатахуун зарцуулалтын нэмэгдлийг 5 хувь байсныг шатахуун зарцуулалтын судалгаа, туршилтын ажлын үр дүнг үндэслэн 25 хувиар шинэчлэн тогтоож өгсөн. Мөн Дэд бүтцийн сайдын 19 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар тогтоосон Нийслэл болон аймгийн төвүүдэд ажиллах автомашины шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх болон хорогдуулах хувь хэмжээ буюу өндөршилийн нэмэгдлийг авто замын нөхцөлөөс хамааруулж шатахуун зарцуулалтыг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлд тооцдог, одоогийн ашиглаж буй автомашинуудын хөдөлгүүрт уг өндөршилийн нөлөөллийг хамгийн бага байхаар тооцон үйлдвэрлэж байгаа зэрэг нөхцөлийг үндэслэн уг өндөршилийн өөрчлөлтийг тусгасан хувь хэмжээг хассан болно. Харин технологийн тээвэр гүйцэтгэж буй автомашин, тусгай төхөөрөмж бүхий автомашин, автомашиныг хүйтний улиралд халаах зэрэг автомашины гүйлтээр шатахуун зарцуулалтыг тооцож олгох боломжгүй нөхцөлд 1 цагт зарцуулах

шатахууны хэмжээ буюу мото.цагийн шатахуун зарцуулалтыг уг нормд шинээр тусгаж өгсөн.

### **3 дугаар хавсралт: Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж жишээ.**

Автомашины жишиг нормыг баримжаалан үндсэн норм тогтоох, шатахуун зарцуулалтын нэмэгдлүүдийг хэрхэн тооцох, автомашины ажилд олговол зохих шатахууны хэмжээг тооцох зэрэг аргачлал, заавар, зөвлөмжийг автомашины бүхий аж ахуйн нэгж, иргэд ашиглах боломжтой хэрэглэхэд энгийн, тодорхой ойлгомжтой байлгах зарчмыг баримтлан шинэчлэн боловсруулсан.

### **4 дүгээр хавсралт Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар, гүйлтийн норм**

Дэд бүтцийн сайдын 19 дүгээр тушаалаар батлагдсан Автомашины эдэлгээний нөөцийн жишиг норм нь үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний нөөцийг марк загвараар жагсаалтаар батлуулсан норм юм. Иймд өнөөгийн нөхцөлд үйлдвэрлэгчид эдэлгээний нөөцийн доод хязгаарыг гүйлтээр, хугацаагаар тогтоож байгаа бөгөөд үйлдвэрлэгчээс өгсөн эдэлгээний нөөцийн доод хязгаарыг автомашины марк, загвар бүрээр, жагсаалтаар тогтоох шаардлагагүй гэж үзэн үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний нөөцийг шууд мөрдөх заалтыг нэмж тусгасан. Харин манай орны ашиглалтын нөхцөл, ажил үйлчилгээний онцлогоос хамаарах нөхцөлүүдийг хэвээр үлдээн зарим нэмэлтийг оруулсан.

### **5 дугаар хавсралт: Автомашины сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм**

Дэд бүтцийн сайдын 19 дүгээр тушаалаар батлагдсан 9-11 дүгээр хавсралтад тусгагдсан автомашины агрегат зангилаа, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийг нэгтгэн 5 дугаар хавсралтад тусгасан. Уг тушаалаар баталсан ашиглалтын нөхцөлийг тусгасан заалтуудыг хэвээр үлдээж зарим нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаж өгсөн бөгөөд үйлдвэрлэгчээс тогтоосон сэлбэг хэрэгслийн эдэлгээний нөөцийг мөрдөх тухай заалтыг нэмж тусгасан.

Гэрээт ажлын хүрээнд шинэчлэн боловсруулсан Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормын төслийг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн албан бичгээр болон ЗТХЯ-ны цахим хуудсанд байршуулан санал авч төсөлд тусган Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормын шинэчлэн боловсруулаад байна.

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ”